



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А-213

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт  
оруулах, зардал гаргах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2018 оны "Нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын алдар цолтон ахмад настанд "Нэмэгдэл олгох тухай" Төрийн нарийн бичгийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А-13 дугаар тушаалын хавсралтад Монгол улсын Хөдөлмөрийн баатар цол хүртсэн Готовын Тойвгой, аж үйлдвэрийн гавьяат Цэрэнгийн Цэцэгбал, Дамбын Самдан, Жамцын Сүхболд, Худалдааны гавьяат ажилтан Галсангийн Цэвээндорж нарыг нэмж, нэмэгдлийг сар бүр олгосугай.

2. Салбарын алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдлийг өргөдөл гаргасан өдрөөс тооцож, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Ахлах нягтлан бодогч /Ө.Мандухай/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Т.Гантогтох/-т даалгасугай.

ДАРГА  Т.ЖАМБАЛЦЭРЭН

00000854